

БАТЛАН ДААЛТЫН ГЭРЭЭ

20 ... оны ... дугаар
сарын ...-ний өдөр

№

Улаанбаатар хот

Батлан даалтын гэрээ /цаашид “Тэрээ” гэх/-г нэг талаас:овогтой /РД:...../
би /цаашид “Батлан даагч” гэх/ нөгөө талаас“.....” ХХК түүнийг төлөөлж захирал
/цаашид “Үүрэг гүйцэтгүүлэгч” гэх/, /цаашид хамтад нь “талууд” гэх/ нар нь Монгол Улсын Иргэний
хуулийн 189 дүгээр зүйлийн 189.1 дэх хэсэг, 458-р зүйл, “.....” ХХК –ийн үүрэг гүйцэтгэгчтэй
байгуулсан гэрээг тус тус үндэслэн харилцан тохиролцож, дараах нөхцөлөөр байгуулав.

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1. Энэхүү гэрээгээр батлан даагч тал нь үүрэг гүйцэтгүүлэгч талын өмнө 2016 оны ... дүгээр сар ...-ний өдрийн -ний/захиалагч буюу үүрэг гүйцэтгүүлэгч/ болон / үүрэг гүйцэтгэгч/ нарын хооронд байгуулагдсангэрээний дагуу үүрэг гүйцэтгэгч тал нь үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө хүлээсэн үүргээ гүйцэтгэж чадна гэдгийг баталж, хэрэв гэрээний үүргээ зөрчсөн, үүргээ гүйцэтгээгүй тохиолдолд энэхүү гэрээгээр тохиролцсон хэмжээгээр үүрэг хүлээж гэрээний нөхцлийг хүлээн зөвшөөрөв.
- 1.2. Батлан даалтын дээд хэмжээ 0,000,000 /тоогоор//үсгээр/ төгрөгийн үнийн дүн бүхий байх бөгөөд батлан даагч нь үүрэг гүйцэтгэгч үүргээ гүйцэтгээгүй тохиолдолд**ОВОГТОЙ..... НЬ-ТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ ҮҮРГЭЭ ЗӨРЧСӨН, ҮҮРГЭЭ ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАР, ЧАДАМЖГҮЙ БОЛСОН, НАС БАРСАН ТОХИОЛДОЛД ,000,000 /тоогоор/ /үсгээр/ төгрөгийн батлан даалтын үнийн дүнг болон учирсан гэм хор, гэрээ дуусгавар болохтой холбогдон гарах зардал, шүүхийн зардал, торгууль зэргийг батлан даагчхариуцна.**
- 1.3. Батлан даалтын гэрээгээр батлан даагчийн хүлээсэн үүрэг нь үүрэг гүйцэтгэгчээс үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө хүлээсэн үүрэгт хамаарна.

ХОЁР. БАТЛАН ДААГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 2.1. Батлан даагч нь үүрэг гүйцэтгэгч үндсэн гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж чадна гэдгийг үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө баталж, гүйцэтгээгүй бол түүний өмнөөс бүрэн хариуцах үүрэг хүлээж байна.
- 2.2. Батлан даагч нь өөрийн хүсэлт, санаачилгаар энэхүү гэрээний дагуу батлан даалт гаргаж байгаа тул энэхүү гэрээг нэг талын санаачилгаар цуцлах, гэрээгээр хүлээсэн үүргээсээ татгалзах эрхгүй.
- 2.3. Үүрэг гүйцэтгүүлэгчээс батлан даагчид шаардлага гаргавал үүрэг гүйцэтгэгчээс үүрэг гүйцэтгүүлэгчийн эсрэг гаргах бүх татгалзлыг батлан даагч гаргах эрхтэй.
 - 2.3.1. Үүрэг гүйцэтгүүлэгч гэрээг биелүүлээгүй
 - 2.3.2. Үүрэг гүйцэтгэгч мөнгөн төлбөрийн үүргээс өөр үүргийг гүйцэтгэх боломжгүй болсон.
 - 2.3.3. Үндсэн үүргийн хөөн хэлэлцэх хугацаа дуусгавар болсон.
 - 2.3.4. Өөрчлөгдөх болзол бий болсноор үндсэн үүрэг хүчин төгөлдөр бус болсон.
- 2.4. Үүрэг гүйцэтгүүлэгчийн эсрэг гаргаж болох татгалзлаасаа үүрэг гүйцэтгэгч татгалзсан ч батлан даагч татгалзах эрхээ алдахгүй.
- 2.5. ... /*Үргэлжлэл бий* /